



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2000 оны 4 дугаар
сарын 17-ны өдөр

Дугаар 83

Улаанбаатар хот

Ахмадын өргөөний дүрэм
батлах тухай

1. Нийслэлийн ахмадын өргөөний дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Шинэ гутам эхлэн ажиллаж байгаа тул 2000 оны төсөвт зарданд 11 сая төгрөгийн санхүүжилт олгохыг Санхүүгийн хэлтэс /Д. Гонгор/-т зөвшөөрсүгэй.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ

М. ОНХБОЛД



Нийслэлийн Засаг даргын 2000 оны
6-р сараар захирамжийн хавсралт

Нийслэлийн Ахмадын өргөөний дүрэм.

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хуулийн этгээд болох Нийслэлийн Ахмадын өргөө нь (цаашид "өргөө" гэх) Нийслэлийн Засаг дарга түүний тамгын газрын удирдлага дор Нийслэлийн Ахмадын байгууллагатай хамтран өндөр настангуудын нийгмийн хамгаалал, эрүүл мэндэд туслах ажлыг зохион байгуулах, үйлчлэх үүрхтэй аж ахуйн тооцсон дээр ажиллах үйлдвэрийн газар мөн.

2. Оноосон нэр нь "Нийслэлийн Ахмадын өргөө", Хаяг Сүхбаатар дүүргийн 1-р хороо "Энхтайвны өргөн чөлөө" гудамж.

3. Тус өргөө нь аж ахуйн тооцсон дээр ажиллах хуулийн этгээд мөн.

4. Дүрмийн сан нь: а/ үндсэн хөрөнгө нь 7.0 тэрлээр Нийслэлийн оячийн газартай өмч эзэмшлэйн гэрээгээр эзэмшиж байгаа хөрөнгө, б/ эргэнийн хөрөнгө байхгүй.

Хоёр. Өргөөг үүсгэн байгуулагч

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нь тус байгууллагын үүсгэн байгуулагч татан буулгана.

2. Өргөөний захирлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч томилж, чөлөөлнө.

Гурав. Өргөөний үүрэг, орх хэмжээ

1. Өргөөг байгуулах тухай шийдвэр гарч, хуулинд заасан журмаар бүртгүүлснээр хуулийн этгээдийн орхтой болно.

2. Өргөө нь хуулийн этгээдийн орх эдлэх ба орх зүйн харилцаанд орох эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус орх эдлэх, үүрэг хүлээх шүүх орбитрийн байгууллагад их хэмжээгч ба хариуцагчаар оролцох орхтой.

3. Өөрийн нэр бүхий тэмдэг, албан бичгийн хуудас данстай байна.
4. Байрны ашиглалт, тоног төхөөрөмж, эд материалыг Нийслэлийн өмчийн газартай тохиролцож, тус газартай байгуулсан гэрээнд заасны дагуу хийнэ.
5. Гэрээгээр эзэмшиж буй эд хөрөнгийн бүрэн байдлыг хангаж зориулалтын дагуу ашиглана.
6. Тус байгууллага нь доорхи үйл ажиллагааг явуулна. Үүнд:
 - а/ Ахмад настны нийгмийн хамгаалал, эрүүл мэндэд түслэх, сэтгэл зүйн таатай нөхцөл бүрдүүлэх, сургалт, семинар, уулзалт явуулах, үзвэр үйлчилгээ зохиох болон ахмад залуу үеийн холбоог бэхжүүлэн, үндэсний зан заншил ёс зүйг өвлүүлэх зэрэг олон талт үйл ажиллагааг зохион байгуулах.
 - б/ Өргөө нь нийслэлийн ахмадуудтай холбоотой асуудлаар тор захиргаа төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.
 - в/ Өөрийн өрнө болон гадаадын ахмад настуудын ажил амьдралтай танилцаж, тэднийг сурагчлах, холбоо тогтоож хамтран ажиллах.

Дөрөв. Захирлын эрх үүрэг

1. Байгууллагын дотоод журмыг батлан мөрдөж ажиллана.
2. Өргөөний ажиллагсадтай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилд авах, цолоолох, сахилгын арга хэмжээ авах, цалин урамшил тогтоох зэрэг ажлуудыг зохио хууль журмын дагуу хариуцна.
3. Байгууллагын батлагдсан төслийг захиран зарцуулна.
4. Холбогдох хууль тогтоомж, эрхүү дүрэм болон Нийслэлийн удирдлагаас өгсөн үүрэг даалгавар эрх хэмжээний хүрээнд өргөөний өдөр тутмын үйл ажиллагааг удирдна.
5. Эрх хэмжээнийхээ хүрээнд өргөөг тогтоолох, гэрээ хэлцэл хийх эрхтэй.
6. Эрх хэмжээнийхээ хүрээнд дагаж мөрдөх тушаал гаргана.
7. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн өмнө ажлаа галгана.

8.Тогтоосон журмын дагуу санхүүгийн анхан шатны бүртгэлийн хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл,мэдээ судалгааг зохих заавар журмын дагуу хугацаанд нь гаргана.

9.Монгол улсын холбогдох хууль тогтоомжинд заасан бусад үүрэг хүлээнэ.

Тав. Санхүү бүртгэл

1.Санхүү бүртгэлийн систем Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу явагдна.

2.Анхан шатны баримт үндэслэн тайлан тэнцэл унирлаар гаргаж татвар,санхүүгийн байгууллагад тушаана.

Зургаа. Санхүүгийн хяналт

1.Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт төмнийн алимент бахиран зарцуулалтанд хяналт шалгалтыг холбогдох хуулийн дагуу хийж хянажүүрнэ.

2.Эх ахуй санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын мөрсөх эрх хянах дүн бичлүүрнэ.

Долоо. Бусад асуудал

1.Энэхүү дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэр нь дүрмийн салангүй хэсэг болно.

2.Энэ дүрмэнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр улсын бүртгэлийн болон эрх бүхий байгууллагад мэдэгдэж бүртгүүрнэ.